

1. Улаанбаатар хотод 12 салбартайгаар үйл ажиллагаа явуулж буй М-март сүлжээ дэлгүүрээр зочиллоо



М-март хүнсний сүлжээ дэлгүүрүүд хариуцсан хүний нөөцийн менежер С.Эрдэнэтунгалагтай (зүүн талаас гурав дахь) дурсгалын зураг даруулав.

DPUB2 төслийн зүгээс ААНБ-уудтай ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг сайжруулах талаар уулзалт хийж буй мэдээг цувралаар хүргэж байгаа билээ. Энэ удаад бид дотоодын топ компаниудын нэг “Макс групп”-ын охин компани болох М-март үндэсний сүлжээ дэлгүүрийн захиргаа, хүний нөөц хариуцсан ажилтнуудтай уулзалт хийсэн тэмдэглэлээс хүргэж байна.

Макс групп нь 5 чиглэл салбарт үйл ажиллагаагаа явуулдаг ба нийт 3000 гаруй ажилчидтай. Худалдаа үйлчилгээний М-мартын сүлжээ дэлгүүрийн хувьд хотод 12 салбартай. Бид бүхэн Захиргаа, хүний нөөцийн албаны дарга С.Эрдэнэтунгалаг болон хүний нөөц, жижиглэн худалдаа хариуцсан мэргэжилтнүүдтэй уулзалт яриа хийсэн юм. “Макс Групп”-ын

ерөнхий бодлогын хүрээнд М-март сүлжээ дэлгүүр нь бүх салбартаа ХБИ-ийг ажиллуулж буй ч харамсалтай нь он гарснаас хойш цалин болоод ар гэрийн асуудлаас шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын тоо багассан байна.

Одоо тус компанид хөгжлийн бэрхшээлтэй 12 хүн ажиллаж байна. Эдгээр ажилчдын дийлэнх нь 1,5-аас дээш жил ажиллаж буй бөгөөд 10 гаруй жил тууштай ажиллаж буй сонсголын бэрхшээлтэй ажилтан ч байна.

Өмнө нь уулзалт хийсэн ААНБ-уудтай ижил асуудал буюу хөгжлийн бэрхшээлтэй ажилтантай хэрхэн харилцах, бусад ажилчдын хандлага, ойлголтыг сайжруулах тал дээр шийдвэрлэх ёстой зүйлүүд байгаа талаар ч М-март дэлгүүрийн зүгээс хэлж байсан. Энэ утгаараа DPUB2 төслөөс зохион байгуулах 4 хоногийн сургалт, семинарт оролцох хүсэлтэй буйгаа илэрхийлж байв.

DPUB2 төсөл ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор М-март болон Макс группынхэнтэй хамтарч ажиллах болсондоо баяртай байна.

2. ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх анхдугаар сургалт

“ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх анхдугаар сургалт” 4-р сарын 18-21-ний өдрүүдэд 4 өдрийн турш амжилттай зохион байгуулагдлаа.

Сургалтад ТББ-уудын төлөөллөөс хараа болон сонсгол, бие эрхтний бэрхшээлтэй 19 хүн оролцож, гэрчилгээгээ гардан авлаа.



Монгол улс дахь ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх сургалтын дараа

СЭДЭВ

Улаанбаатар хотод 12 салбартайгаар үйл ажиллагаа явуулж буй М-март сүлжээ дэлгүүрээр зочиллоо

ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх анхдугаар сургалт

Ажлын байрны дадлагажуулагчийн анхан шатны хоёр дахь удаагийн семинар амжилттай зохион байгуулагдлаа

DPUB2

Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх

3. Ажлын байрны дадлагажуулагчийн анхан шатны хоёр дахь удаагийн семинар амжилттай зохион байгуулагдлаа

5-р сарын 2-3-ны өдрүүдэд “Ажлын байрны дадлагажуулагчийн анхан шатны семинар”-ыг амжилттай зохион байгууллаа. Анхдугаар семинар танхим болон онлайн хосолсон хэлбэрээр зохион байгуулагдсан бол энэ удаагийн семинарт Япон улсаас 3 мэргэжилтэн багш нар хүрэлцэн ирсэн юм.



Огава Хироши багш ажлын байрны дадлагажуулагчаар ажиллаж байсан өөрийн туршлага болон ажлын байрны үнэлгээний талаар тайлбар хийж байна.



Сакай Дайсүкэ багш “ААНБ-уудтай уулзалт хийх” дасгал ажлын талаар тайлбар хийж байна.

Семинарын эхний өдөр ажлын байрны дадлагажуулагчийн үүрэг, үнэлгээ болон тохирсон ажилд оруулах тухай, ажлын байран дахь төвлөрсөн дэмжлэг зэргийн тухай танилцууллаа. Оролцогчдын асуултад Огава багш ажлын байрны дадлагажуулагчаар ажилласан өөрийн туршлага дээр үндэслэн тодорхой бөгөөд дэлгэрэнгүй хариулт өгч байлаа.



Инаба Кентаро багш “Ойлгомжтой заах арга барил” сэдвийн хүрээнд лекц тавьж байна.



Инаба Кентаро багш “Ойлгомжтой заах арга барил” сэдвийн хүрээнд лекц тавьж байна.

Семинарын хоёр дахь өдөр, оролцогчид хоёр группд хуваагдан “ААНБ-уудтай уулзалт хийх”, “Ойлгомжтой заах арга барил” гэсэн сэдвийн хүрээнд дасгал ажилд хамрагдсан юм. Оролцогчид ажлын байрны дадлагажуулагчийн дүрд тоглож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд оруулахын тулд ААНБ-уудтай ямар байдлаар ярилцах, оюуны бэрхшээлтэй иргэдэд ажлын дарааллыг нь хэрхэн хялбар бөгөөд системтэй заах арга барилын талаар суралцлаа.

Хаалтын үйл ажиллагааны үеэр Огава багш “Монгол Улсын засгийн газар Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлэхээр болсонд туйлын баяртай байна. Цаашид тус үйлчилгээ Монгол Улсад амжилттай нутагшихыг чин



Оролцогчид ажлын байрны дадлагажуулагчийн дүрд тоглож, “Ойлгомжтой заах арга барил”-ын талаар суралцаж байна.

сэтгэлээсээ хүсэж байна” хэмээн онцоллоо.

 dpub.jica@gmail.com

 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160

 <https://www.facebook.com/jicadpub1and2>

 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

